



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/404

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Усны эхийг бүрдүүлэгч ойн санг хамгаалах зорилгоор ойн хортны судалгааны (500000 га, ой бүхий сумдад) ажлыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарсан “Аглаг ой” ХХК-тай 39 336 000 (гучин ес сая гурван зуун гучин зургаа мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2. “Аглаг ой” ХХК-ийн ажлын гүйцэтгэлд холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Аглаг ой” ХХК-ийн захирал (Ч.Дэлгэрцэцэг)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010380